


КОВИД-19 цар тахлын яаралтай тусламж



the
power of
humanity



Австралийн Улаан Загалмай нийгэмлэг Австрали Улсад түр визээр оршин суугаа КОВИД-19 цар тахлын нөлөөнд өртсөн хүмүүст тусламж үзүүлж байна.

Бид Австрали Улсын төрөл бүрийн төрийн байгууллага, агентлагуудаас өгсөн хандивын хүрээнд хүнсний тусламжийн багц олгох, хүнд нөхцөлд байгаа өрхөд туслах, нэг удаагийн мөнгөн тусламж үзүүлэх зэргээр туслаж чадна.

Хэрэв та дараах шалгуурыг хангаж байвал энэхүү тусламжинд хамрагдах боломжтой:

- Австрали Улсын иргэн буюу байнгын оршин суугч биш байх
- Хоол хүнс авах эсвэл эмчилгээний зардал төлөх зэрэг яаралтай тусламж хэрэгтэй байгаа
- Өөрийн хэрэгцээг хангах хэмжээний орлогогүй буюу хадгаламжиндаа мөнгөгүй байх

Яаж хамрагдах вэ?

Та манай redcross.org.au/emergencyrelief цахим системээр орж өргөдөл гаргах шаардлагатай.

Өргөдлөө гаргахын өмнө та дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байх хэрэгтэй:

- Визний статусыг нотлох баримт, тухайлбал паспортын дугаар
- Данс эзэмшигчийн нэр, BSB дугаар, дансны дугаар харуулсан банкны албан бичиг.

Хэрэв та өөрийн визний статусыг мэдэхгүй байгаа, эсвэл хүчин төгөлдөр визгүй байсан ч та өргөдөл гаргаж болох бөгөөд бид таньтай холбогдож, таны өргөдлийн талаар ярилцана.

Та нарт миний хувийн мэдээлэл яагаад хэрэгтэй байгаа юм бэ?

Таны цахим өргөдөл бөглөхдөө өгсөн мэдээлэл Улаан Загалмай Нийгэмлэгт ирнэ. Энэ нь төрийн байгууллагын мэдээллийн сүлжээ, систем биш учраас таны одоогийн болон хойшид гаргах визэнд нөлөөлөхгүй.

Хэрэв би өргөдлийг бөглөхдөө тусламж хэрэгтэй болбол яах вэ?

Хэрэв та өргөдлийг өөрөө бөглөж чадахгүй бол гэр бүлийн гишүүн, найз нөхөд, эсвэл бусад байгууллага, хүмүүсээс тусламж хүсч болно. Таны өргөдөл ирсэний дараа манай Улаан Загалмайн ажилтан таны өргөдлийг хянах бөгөөд таньтай утсаар холбогдож магадгүй. Өргөдөл гаргах шат дараалсан зааварчилгааг Улаан Загалмайн [вэбсайт](#) дээрээс мөн харж болно.

Тусламжийн мөнгийг авахаар бол би хир удаан хүлээх вэ?

Бид маш олон өргөдөл хүлээн авч байгаа тул таны өргөдөлд хариу өгөхгүй удаж болно. Тиймээс та хандивын мөнгө хэзээ орж ирэх талаар утасдах, имэйл бичих шаардлагагүй бөгөөд манай ажилтанг таньтай холбогдох хүртэл хүлээнэ үү.